



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 23 өдөр

Дугаар 393

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ухаалаг засаг-1” төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 74,900,000.00 (далан дөрвөн сая есөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 35,774,155.25 (гучин таван сая долоон зуун далан дөрвөн мянга нэг зуун тавин таван төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөлтийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



132001907

19-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 2-дугаар сарын 23-ны өдрийн
293 дугаар тогтоолын хавсралт

"УХААЛАГ ЗАСАГ-1" ТӨСЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ниссан теана, 86-09 УБЗ, 1N4AL3AP8GC177869	2010/2017	74,900,000.00	35,774,155.25	39,125,844.75
	НИЙТ ДҮН		74,900,000.00 (далан дөрвөн сая есөн зуун мянга)	35,774,155.25 (гучин таван сая долоон зуун далан дөрвөн мянга нэг зуун тавин таван төгрөг хорин таван мөнгө)	39,125,844.75 (гучин есөн сая нэг зуун хорин таван мянга найман зуун дөчин дөрвөн төгрөг далан таван мөнгө)